

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХҮН АМЫН ХУВАНЦАР САВНЫ ТАЛААРХ
МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДЛЫГ ТОГТООХ СУДАЛГАА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ

1. Судалгааны ажлын үндэслэл:

Хүнсний зориулалтын бус хуванцар савны найрлагад ордог химийн бодисууд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд шилжин хүний биед орж, хуримтлагдан ямар нэгэн шинж тэмдгээр шууд илэрч нөлөөлдөггүй, харин удаан хугацааны хэрэглээний явцад тухайн хүний биед байгаа өвчин эмгэгийг дэмжиж, дархлаа тогтолцооны хэвийн үйл ажиллагааг бууруулж чихрийн шижин, үргүйдэл, арьсны өвчин, мэдрэлийн согог зэрэг олон төрлийн өвчний эх үүсвэр болдог гэж үздэг.

Улсын хэмжээнд зургаан сая зориулалтын бус хуванцар сав худалдаанд эргэлдэж байгаагаас хөдөөгийн ард иргэдийн 80-90 хувь нь олдоц ихтэй, үнэ хямд гэх шалтгаанаар ундны ус, сүү, айраг зэрэг хүнсний шингэн бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэхэд зориулалтын бус хуванцар сав хэрэглэж байна. (Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, 2019)

Хуванцар савны хамгийн аюултай нь Америкийн эрдэмтэд хуванцар савны найрлагад ордог бисфенол А нь бэлгийн гормоны үйл ажиллагааг бууруулж, хөхний хорт хавдарыг үүсгэдэг бөгөөд эр бэлгийн эсийн тоог илэрхий бууруулдаг болохыг тогтоосон байна.

Хүнсний зориулалтын бус хуванцар саванд хонуулсан усны найрлагыг төвлөрсөн сүлжээний усны үзүүлэлттэй харьцуулахад төмөр 2 дахин, нитрит 11 дахин, аммиак 48 дахин их байгааг тогтоожээ. Түүнчлэн хуванцар саванд хонуулсан сүүнд хар тугалгын агууламж “Хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металлын үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 4504:2008” стандартад зааснаас 3-4 дахин, айрганд 4,4 дахин их байв. Энэ нь хүнсний зориулалтын бус хуванцар савны бүрэлдэхүүн дэх химийн хорт бодисууд хүнсний шингэн бүтээгдэхүүнд шилжин уусч улмаар хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл учруулах өндөр эрсдэлтэй байгааг харуулж байна. (Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, 2016)

Зориулалтын бус хуванцар саванд хадгалсан усан дахь хар тугалга ДЭМБ-ын зөвлөмж хэмжээ болон Монгол Улсад мөрдөж байгаа стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 60-800, формальдегид 1800-6900 дахин их байгааг тус тус тогтоосон. Формальдегид нь хүний биед хорт хавдар үүсгэдэг бодис юм. /Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, 2016/

Хуванцар савны хамгийн аюултай нь ямар нэгэн шинж тэмдгээр шууд илэрч нөлөөлдөггүй, харин аажим аажмаар хүний эрүүл мэндэд нөлөөлж тухайн хүний биед байгаа өвчин эмгэгийг дэмжиж дархлааг муутгадаг байна.

Хуванцар материалын зориулалт, тэмдэглэгээг таньж мэдэхгүйгээс зориулалтын бус шингэн болон хуурай хүнс савлаж хадгалах, буцалсан халуун бүлээн зүйл хийх, өндөр температурт халаах, нар салхинд тавих гэх мэтчилэн тухайн саван дахь химийн элемент хоол хүнстэй урвалд орох бүхий л хортой орчинг бүрдүүлдэг.

Иймд хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах, зориулалтын бус савны хор холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах,

хуванцар савны олон улсын тэмдэг, тэмдэглэгээний талаар зохих мэдлэгтэй байх зайлшгүй шаардлагатай байна.

2. Судалгааны ажлын зорилго:

Өвөрхангай аймгийн хүн амын хуванцар савны талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлж, үр дүнд үндэслэн арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх

3. Судалгааны ажлын зорилт:

- Хүн амын хуванцар савны талаарх мэдлэгийг үнэлэх
- Хүн амын хуванцар савны талаарх хандлагыг тогтоох
- Хүн амын хуванцар савны талаарх дадлыг үнэлэх

4. Судалгааны ажлын таамаглал:

- Хүн амын хуванцар савны мэдлэг хот, хөдөөд ялгаатай байна.
- Ундны усны зориулалтаар ашиглаж буй зориулалтын бус хуванцар савны хэрэглээ их байна.

5. Судалгааны ажлын шинэлэг тал:

Хүн амын хуванцар савны талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх судалгааг аймгийн хэмжээнд зохион байгуулж байгаа нь шинэлэг юм.

6. Практик ач холбогдол:

Судалгааны үр дүнд цаашид хуванцар савны талаарх мэдлэг, хандлага, дадлаас үүдэлтэй эрсдлийг бууруулах талаар нотолгоонд суурилсан арга хэмжээг боловсруулах, орон нутгийн онцлогт тохирсон үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд суурь мэдээлэл, нотолгоо болж байгаагаараа давуу талтай юм.

7. Үндсэн ойлголтын тайлбар:

“Хуванцар материал гэдэг нь”- Газрын тос, байгалийн хийн молекул болон бусад олон төрлийн нэгдэл эдгээр нь мономоор үүсгэдэг бөгөөд олон гинжин хэлхээтэй мономерийг (Poly) полимер гэж нэрлэнэ.

“Хуванцар савны төрөл”- Уян хатуу шинж чанар, химийн найрлага, урвалд тэсвэртэй байдал зэргээс хамааран 7 төрөлд ангилдаг.

1 /PETE/- Терепталатийн полиэтилен

2 /HDPE/- Маш өндөр нягтралтай полиэтилен

3 /V/- Винил эсвэл поливинил агуулсан хуванцар

4 /LDPE/- Бага нягтралтай полиэтилен

5 /PP/- Полипропилен

6 /PS/- Полистирол

7 /OTHER/- Бусад хуванцар

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ

Судалгааны ажлын загвар:

Өвөрхангай аймгийн хүн амын хуванцар савны талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэхдээ нэг агшингийн судалгааны загварыг ашиглана. Судалгааны мэдээллийг тоон судалгааны анкет олон ажиглалтын аргыг ашиглан цуглуулна.

Судалгааны хамрах хүрээ, түүвэрлэлт:

Нийт өрхийн тоог сум тус бүрээр (n=34436) суурь үзүүлэлт болгон авч 95 хувийн магадлал (1,96), алдааны хязгаар (0,09), түүврийн бус алдааг 5 хувиар тооцож 2065 иргэнийг судалгаанд хамруулахаар тооцно.

$$n = \frac{N * z^2 * p * (1 - p)}{(N - 1) * e^2 + z^2 * p * (1 - p)} = \dots$$

N- Эх олонлог (12178)

Z2 – Илтгэх хязгаар 1.96 (95%)

P – Үзүүлэлтийн суурь түвшин (0.5)

e2 – Алдааны хязгаар 0.09

№	Сумын нэр	Эх олонлог	Түүвэр хүн ам
1	Арвайхээр	10089	118
2	Баруунбаян-Улаан	704	112
3	Бат-өлзий	2319	117
4	Баянгол	1084	104
5	Баянөндөр	1121	107
6	Богд	1521	112
7	Бүрд	819	112
8	Гучин-Ус	629	100
9	Есөнзүйл	864	103
10	Зүүнбаян-Улаан	1234	107
11	Нарийнтээл	940	112
12	Өлзийт	728	99
13	Сант	1036	110
14	Тарагт	1033	110
15	Төгрөг	837	100
16	Уянга	2768	115
17	Хайрхандулаан	1074	103
18	Хархорин	3663	113
19	Хужирт	1973	111
Нийт			2065

1. Мэдээлэл цуглуулалт:

Хүн амын хуванцар савны талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлохдоо урьдчилан бэлтгэсэн **3 бүлэг 26 асуумжаар авна**. Асуумжын бүтэц нь:

- Ерөнхий мэдээллийн хэсэг: Нас, хүйс, гэр бүл, харьяалал, өрхийн орлого, хөдөлмөр эрхлэлт зэрэг мэдээллийг багтаасан.
- Хүн амын хуванцар савны талаарх мэдлэгийг үнэлэхдээ 8 асуумж
- Хүн амын хуванцар савны талаарх хандлагыг үнэлэхдээ 9 асуумж
- Хүн амын хуванцар савны талаарх дадлыг тодорхойлохдоо 9 асуумжаар тус тус авна.

2. Мэдээллийн чанар:

- Түүврийн нэгжийн жагсаалтыг бүрэн бэлтгэх, сонгогдсон нэгжийг судалгаанд заавал хамруулах
- Асуулгын хуудас болон зааварт заасан чиглэлийн дагуу мэдээллийг цуглуулна. Мэдээлэл цуглуулах явцад ойлгомжгүй зүйл, бэрхшээл тулгарсан үед НЭМХ-ийн мэргэжилтэн Б.Оюунчимэг /88689110/ зөвлөлдөж, асуудлыг шийдэх байдлаар ажиллана.

3. Мэдээлэл боловсруулалт:

Тоон судалгааны статистик боловсруулалтыг SPSS программын 23 хувилбарыг ашиглан дүгнэлт хийнэ. Үр дүнг боловсруулахдаа тухай хувьсагчийн тархалтаас хамааруулаад тоо мэдээлэлд Pearson Correlation-ийг, хувиар илэрхийлсэн мэдээлэлд Pearson Chi-square ашиглах бөгөөд асуумжын найдвартай байдлыг үнэлэхдээ Cronbach Alpha-г тодорхойлно.

Хувь хүний мэдээллийг зөвхөн судалгааны ажилд ашиглах бөгөөд судалгааны үр дүнг мэдээлэхдээ хувь хүний нууцыг хадгална.

4. Судалгааны үр дүн

Хүснэгт 1. Хүн ам зүйн мэдээлэл

Үзүүлэлт	Ангилал	Тоо	Хувь
Нас	10-19	93	6.4
	20-29	206	14.1
	30-39	362	24.8
	40-49	322	22.1
	50-59	260	17.8
	60-69	155	10.6
	70-79	51	3.5
	80-89	8	0.5
90-с дээш		1	0.1
	Ам бүл		
	1-2	367	25.2
	3-4	645	44.2
5-с дээш	446	30.6	
Хүйс	Эр	460	31.6
	Эм	998	68.4
Харьяалал	Арвайхээр	98	6.7
	Баруунбаян-Улаан	105	7.2
	Бат-Өлзий	108	7.4
	Баянгол	101	6.9
	Баян-Өндөр	105	7.2
	Богд	51	3.5
	Бүрд	59	4.0
	Гучин-Ус	88	6.0
	Есөнзүйл	27	1.9
	Зүүнбаян-Улаан	102	7.0
	Нарийнтээл	73	5.0
	Өлзийт	52	3.6
	Сант	84	5.8
	Тарагт	73	5.0
	Төгрөг	91	6.2
	Уянга	73	5.0
	Хархорин	59	4.0
Хужирт	109	7.5	
Боловсрол	Дээд	413	28.3
	Тусгай дунд /коллеж/	157	10.8
	Бүрэн дунд	406	27.8
	Бүрэн бус дунд	283	19.4
	Бага	184	12.6
	Боловсролгүй	15	1
Гэрлэлтийн байдал	Гэрлэсэн	1138	78.1
	Гэрлээгүй	251	17.2
	Хамтран амьдрагчтай	27	2
	Бэлэвсэн	40	2.7

Өрхийн орлого	1-549999 төгрөг	211	14.5
	550000-999900 төгрөг	717	49.3
	1000000-1999900 төгрөг	359	24.6
	2 сая-с дээш төгрөг	171	11.7
Хөдөлмөр эрхлэлтийн байдал	Төрийн байгууллага	458	31.4
	Төрийн бус байгууллага	92	6.3
	Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	236	16.2
	Тогтмол цалингүй хөдөлмөр эрхэлдэг /улирлын чанартай/	66	4.5
	Оюутан, сурагч	95	6.5
	Тэтгэвэрт	278	19.1
	Ажилгүй /хөдөлмөрийн чадвартай/	99	6.8
	Ажилгүй /хөдөлмөрийн чадваргүй/	18	1.2
	Малчин	116	8

Нийт судалгаанд оролцогчдыг насны бүлгээр авч үзвэл 46.9 хувь нь 30-49 нас, 4.1 хувь нь 70-с дээш насны иргэд, 68.4 хувь нь эмэгтэй, 44.2 хувь нь 3-4 ам бүлтэй байна.

Боловсролын түвшингээр авч үзвэл 28.3 хувь нь дээд, 27.8 хувь нь бүрэн дунд боловсролтой байсан бол боловсролгүй 15 /1%/ байна. Мөн оролцогчдын 31.4 хувь нь төрийн байгууллагад ажилладаг, 16.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг байсан бол 19.1 хувь нь тэтгэвэрт байдаг байна.

Хүснэгт 2. Хуванцар савны талаарх мэдлэгийн үнэлгээ

	Асуумж	Хариулт	Тоо	Хувь
1	Хуванцар савны тэмдэг, тэмдэглээний талаар мэдээлэл авч байсан уу?	Тийм	780	53.5
		Үгүй	401	27.5
		Мэдэхгүй	277	19
2	Хуванцар савны хэдэн төрлийн тэмдэг, тэмдэглэгээ байдаг вэ?	6	177	12.1
		8	164	11.2
		7	429	29.4
		5	291	20
		3	174	11.9
		Мэдэхгүй	223	15.3
3	Доорх хуванцар савны тэмдэглэгээнүүдээс аль нь хүнсний зориулалтаар ашиглаж болох вэ? /Олон хариулттай/	2 /HDPE/	383	26.3
		4 /LDPE/	363	24.9
		5 /PP/	519	35.6
		1 /PETE/	279	19.1
		3 /V/	63	4.3
4	Доорх хуванцар савны тэмдэглэгээнүүдээс аль нь хүнсний зориулалтаар хэрэглэж болохгүй вэ? /Олон хариулттай/	2 /HDPE/	240	16.5
		4 /LDPE/	176	12.1
		5 /PP/	223	15.3
		1 /PETE/	238	16.3
		3 /V/	298	20.4
		6 /PS/	277	19
7 /OTHER/	319	21.9		
5	Доорх хуванцар савны тэмдэглэгээнүүдээс аль нь зөвхөн нэг удаагийн зориулалтаар ашиглах вэ? /Олон хариулттай/	2 /HDPE/	289	19.8
		4 /LDPE/	265	18.2
		5 /PP/	250	17.1
		1 /PETE/	282	19.3

		3 /V/	245	16.8
	Хүнсний зориулалтын бус	Тийм	1133	77.7
6	хуванцар сав хүний эрүүл мэндэд хортой юу. Үүнийг та мэдэх үү?	Үгүй	104	7.1
		Мэдэхгүй	221	15.2
	Хүнсний зориулалтын бус	Хорт хавдар үүсгэнэ	1101	75.5
	хуванцар сав нь хүний бие	Ургийн гажиг	271	18.6
7	махбодид ямар сөрөг нөлөө үзүүлэх вэ? /олон хариулттай/	Зүрхний судасны гажиг	193	13.2
		Сэтгэн бодох, ой тогтоолт муудах	165	11.3
		Үргүйдэл	164	11.2
		Мэдэхгүй	236	16.2
	Хүнсний зориулалтын бус	Хлорид	264	18.1
	хуванцар сав нь хүний эрүүл	Флатат	184	12.6
8	мэндэд хортой ямар химийн бодисыг ялгаруулдаг вэ? /олон хариулттай/	BPA-бисфенол А	218	15
		Хартугалга	427	29.3
		Хүнцэл	156	10.7
		Мэдэхгүй	603	41.4

Судалгаанд оролцогчдын 29.4 хувь нь хуванцар савны тэмдэг, тэмдэглэгээний төрлийн талаар зөв мэдлэгтэй байна. Хүнсний зориулалтаар ашиглаж болох хуванцар сав нь 5 /PP/ ба 1/PETE/ тэмдэглэгээтэй байна гэж судалгаанд оролцогчдын 27.32 хувь нь зөв хариулсан бол хүнсний зориулалтаар 3/V/, 6 /PS/, 7/OTHER/ тэмдэглэгээтэй савыг хэрэглэж болохгүй гэж 20.4 хувь нь мэдлэгтэй байна.

Судалгаанд оролцогчдын 1133 /77%/ нь хүнсний зориулалтын бус хуванцар сав хэрэглэх нь хүний эрүүл мэндэд хортой гэж үзсэн бол 75.5 хувь нь хүний бие махбодод хорт хавдар үүсгэх сөрөг нөлөөтэй, 16.2 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ.

Мөн хүнсний зориулалтын бус хуванцар сав нь хар тугалга агуулдаг гэж судалгаанд оролцогчдын 29.3 хувь нь үзсэн бол 41.4 хувь нь энэ талаар мэдлэггүй байна.

Хүснэгт 3. Хуванцар савны талаарх дадлын үнэлгээ

	Асуумж	Хариулт	Тоо	Хувь
1	Та ундны усны зориулалтаар ямар төрлийн сав хэрэглэдэг вэ?	Хуванцар сав	1018	69.8
		Төмөр сав	398	27.3
		Модон болон торхон	42	2.9
2	Хуванцар сав хэрэглэдэг бол ямар тэмдэглэгээтэй сав хэрэглэж байна вэ? /савны тэмдэглэгээг харах/	2 /HDPE/	198	19.4
		4 /LDPE/	97	9.5
		5 /PP/	182	17.8
		1 /PETE/	145	14.2
		3 /V/	37	3.6
		6 /PS/	23	2.2
		7 /OTHER/	33	3.2
		Тэмдэглэгээгүй/хөх, цагаан, шар канистер/	303	29.8
3	Та цагаан идээг хадгалахдаа ямар төрлийн сав хэрэглэдэг вэ?	Хуванцар сав	591	40.5
		Төмөр сав	640	43.9

	Модон болон торхон	200	14	
	Даавуун уут, гүзээнд	28	1.9	
4	Хуванцар сав хэрэглэдэг бол ямар тэмдэглэгээтэй сав хэрэглэж байна вэ? /савны тэмдэглэгээг харах/	2 /HDPE/	183	12.6
		4 /LDPE/	71	4.9
		5 /PP/	160	11
		1 /PETE/	141	9.7
		3 /V/	46	3.2
		6 /PS/	24	166
		7 /OTHER/	30	2.1
5	Та ундны ус болон цагаан идээ хадгалах савыг 7 хоногт хэдэн удаа угааж цэвэрлэдэг вэ?	1-2 удаа	823	56.4
		3-4 удаа	334	22.9
		Өдөр бүр	269	18.4
		Угаадаггүй	32	2.2
6	Та саваа цэвэрлэхдээ ямар төрлийн бодис ашигладаг вэ?	Содын уусмал	697	47.8
		Зориулалтын угаагч шингэн бодис	326	22.4
		Цэвэр усаар	396	2.7
7	Та ундны зориулалтаар ямар төрлийн шанага хэрэглэгдэг вэ?	Хуванцар	352	24.1
		Төмөр	898	61.6
		Хөнгөн цагаан	184	12.6
		Модон	24	1.6
8	Та хуванцар шанага хэрэглэдэг бол тэмдэглэгээг бичнэ үү?	2 /HDPE/	47	13.3
		4 /LDPE/	7	2
		5 /PP/	93	26.5
		1 /PETE/	85	24.1
		3 /V/	-	-
		6 /PS/	-	-
	7 /OTHER/	-	-	
	Тэмдэглэгээгүй	120	34.1	
9	Ундны усанд хэрэглэж байгаа савыг хаанаас худалдан авдаг вэ?	Худалдааны төв	1127	77.3
		Зориулалтын хүнсний сав худалдан борлуулдаг компани	160	11
		Хувь хүн	171	11.7


Судалгаанд оролцогчдын 1018 /69.8%/ нь ундны усны зориулалтаар хуванцар сав, хуванцар сав хэрэглэж байгаа оролцогчдын 691 /68%/ хүнсэнд хэрэглэхийг хориглосон хуванцар сав хэрэглэж байна.

Хүнсний зориулалтаар хэрэглэхийг зөвшөөрсөн тэмдэг, тэмдэглэгээгүй хөх сав, шар канистрыг хэрэглэж байна. Энэхүү хуванцар сав нь бисфенол-А гэдэг хорт хавдар үүсгэдэг хортой химийн нэгдэл үүсдэг тул ийм тэмдэглэгээтэй савыг зөвхөн химийн бодисыг хадгалах, зөөвөрлөхөд ашигладаг юм.

Харин цагаан идээг хадгалахдаа 591 /40.5%/ нь хуванцар саванд хадгалдаг бол 45.8 хувь нь төмөр болон даавуун уут, гүзээ зэргийг ашиглаж байна.

Иргэдийн 1127 /77.3%/ нь зах худалдааны төвүүдээс хүнсэнд хэрэглэх савыг худалдаж авч байгаа нь зах, худалдааны төвүүдэд худалдан борлуулж буй савыг хүнсэнд хэрэглэхийг зөвшөөрсөн сав борлуулбал иргэдийн худалдан авах дадал нь өөрчлөгдөж болох юм.

Шанаганы хэрэглээ



Зураг 1. Хүнсний зориулалтаар хэрэглэдэг шанаганы төрөл, хувиар

Оролцогчдын 75.8 хувь нь хөнгөн цагаан, төмөр, модон шанагыг хүнсний зориулалтаар хэрэглэж байгаа сайн дадалтай байгаа бол, 24.1 хувь нь хуванцар шанага, үүний 49.4 хувь нь хүнсэнд хэрэглэхийг зөвшөөрөөгүй тэмдэглэгээтэй шанагыг хэрэглэж байна.


Хүснэгт 4. Хуванцар савны талаарх хандлагын үнэлгээ

	Асуумж	Хариулт	Тоо	Хувь
1	Хуванцар савны тэмдэг тэмдэглэгээг уншиж, таньж чаддаг уу?	Тийм	527	36.1
		Үгүй	559	38.3
		Мэдэхгүй	372	25.5
2	Ундны ус хадгалах болон зөөвөрлөх сав нь тусдаа байдаг уу?	Тийм	993	68.1
		Үгүй	316	21.7
		Мэдэхгүй	149	10.2
3	Ус хадгалах сав нь тагтай юу?	Тийм	1199	82.2
		Үгүй	145	9.9
		Мэдэхгүй	114	7.8
4	Зориулалтын хуванцар сав хэрэглэхийг эрмэлздэг үү?	Тийм	1079	74
		Үгүй	207	14.2
		Мэдэхгүй	172	11.8
5	Сүү, тараг, жүүс, ундааны сав, хоолны сав гэх мэт нэг удаагийн зориулалттай хуванцар савыг хүнсний зориулалтаар дахин хэрэглэдэг үү?	Тийм	756	65.4
		Үгүй	505	34.6
6	Хүнсний зориулалтын усны савыг зах зээлд хямд үнээр худалдаалагдаж байвал та авч хэрэглэх үү?	Тийм	1270	87.1
		Үгүй	188	12.9
7	Хэрэв зориулалтын бус хуванцар савнаас шалтгаалан таны бие махбодидод сөрөг нөлөө үзүүлвэл ямар арга хэмжээ авах вэ?	Эрүүл мэндийн байгууллагад хандаж, эмчээс зөвлөгөө авна	1067	73.2
		Биед илэрч байгаа шинж тэмдэг бага учраас тийм ач холбогдолтой биш	135	9.3

		Ямар ч арга хэмжээ авахгүй	36	2.5
		Мэдэхгүй	220	15.1
8	Хүнсний зориулалтын хуванцар сав худалдан авч хэрэглэхэд ямар бэрхшээл тулгардаг вэ?	Үнэ, өртөг өндөр байдаг	948	65
		Олдоц бага	242	16.6
		Хэрэглэж хэвшээгүй учраас худалдаж авдаггүй	242	16.6
9	Хуванцар савны тэмдэг, тэмдэглэгээ, хэрэглээний талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ? /олон хариулттай/	Телевиз	806	55.3
		Радио	104	7.1
		Цахим сүлжээ	680	46.6
		Эрүүл мэндийн байгууллагаас	509	34.9
		Сонин, сэтгүүл	93	6.4
		Гэр бүл, найз, нөхөд	186	12.8
		Хамт олон	114	7.8

Нийт оролцогчдын 74 хувь нь хүнсэнд хэрэглэхийг зөвшөөрсөн савыг хэрэглэхийг эрмэлздэг боловч 65 хувь нь үнэ өртөг өндөр байдгаас шалтгаалан худалдан авч чаддаггүй гэж хариулсан бол, хямд үнээр худалдаалбал хүнсэнд хэрэглэхийг зөвшөөрсөн савыг худалдан авч хэрэглэнэ гэж дийлэнх хувь нь хариулсан байна.

Мөн оролцогчдын 65.4 хувь нь сүү, тараг, жүүс, ундааны сав, хоолны сав гэх мэт нэг удаагийн зориулалттай хуванцар савыг хүнсний зориулалтаар дахин хэрэглэж байна.



Зураг 2. Хуванцар савны талаарх мэдээллийг авдаг суваг, хувиар

Хуванцар савны тэмдэг, тэмдэглэгээ, хэрэглээний талаарх мэдээллийн 55.3 хувийг телевиз, 46.6 хувийг цахим сүлжээ, 34.9 хувийг эрүүл мэндийн байгууллагаас авч байна. Иймээс иргэдэд телевиз, цахим сүлжээгээр өгөх

мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулж үнэн зөв мэдээллээр хангахад анхаарах шаардлагатай байна.

Судалгааны дүгнэлт:

1. Нийт оролцогчдын 29.4 хувь нь хуванцар савны тэмдэг, тэмдэглэгээний талаар зөв мэдлэгтэй, 70.6 хувь нь буруу мэдлэгтэй байна.
2. Оролцогчдын 45.8 хувь нь ундны ус, цагаан идээ хадгалахдаа хуванцар сав, 54.2 хувь нь төмөр болон модон торхон савыг хэрэглэж байна. Мөн нэг удаа хэрэглэх зориулалттай ундаа жүүс, усны хуванцар савыг нийт оролцогчдын 64.5 хувь нь хүнсний бүтээгдэхүүн хадгалах зорилгоор дахин хэрэглэж байна.
3. Мөн оролцогчдын 87.1 хувь нь хүнсэнд хэрэглэхэд хүний биед хор нөлөөгүй сав нь үнэ хямд бол худалдан авч хэрэглэнэ гэсэн эерэг хандлагатай байна.

Цаашид:

1. Цагаан идээг хүнсний зориулалтын бус хуванцар саванд хадгалж, худалдаалахыг хориглосон засаг даргын шийдвэр гаргаж, худалдаа эрхлэгчдэд хүргэх, хэрэгжилтийг хангуулах ажлыг салбар дундын оролцоотойгоор хэрэгжүүлж, хяналт тавих
2. Хуванцар сав худалдан борлуулж буй иргэд, аж ахуй нэгжүүдэд хуванцар савны хор уршгийн талаар сургалт зохион байгуулж, мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх
3. Хүнсний зориулалтын сав /никель, төмөр, ган, модон/-ны худалдах үнийг бууруулах иргэдэд хөнгөлттэй үнээр худалдахад орон нутгаас дэмжлэг үзүүлэх боломж нөхцлийг судлах
4. Багийн засаг дарга, нийгмийн ажилтан, сайн дурын идэвхтнүүдийг чадавхжуулах сургалтад хамруулан, эдгээр хүмүүсээр дамжуулан хөдөөгийн малчин иргэдэд хуванцар савны хор уршгийн талаар ухуулга, нөлөөллийн ажлыг үр дүнтэй зохион байгуулах

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХҮН АМЫН ХУВАНЦАР САВНЫ ТАЛААРХ
МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДЛЫГ ТОГТООХ СУДАЛГААНЫ АСУУМЖ**

№	Асуулт	Хариулт
Хүн ам зүйн мэдээлэл		
1	Таны нас	A. 10-19 нас B. 20-29 нас C. 30-39 нас D. 40-49 нас E. 50-59 нас F. 60-69 нас H. 70-79 нас G. 80-89 нас K. 90-с дээш
2	Хүйс	A. Эрэгтэй B. Эмэгтэй
3	Ам бүл	A. 1-2 B. 3-4 C. 5-с дээш
4	Оршин суугаа газар /сумаар/
5	Боловсролын түвшин	A. Дээд B. Тусгай дунд /коллеж/ C. Бүрэн дунд D. Бүрэн бус дунд E. Бага F. Боловсролгүй
6	Гэрлэлтийн байдал	A. Гэрлэсэн B. Гэрлээгүй C. Хамтран амьдрагчтай D. Бэлэвсэн
7	Өрхийн орлого
8	Хөдөлмөр эрхлэлтийн байдал	A. Төрийн байгууллага B. Төрийн бус байгууллага C. Хувиараа хөдөлмөр эрхэлдэг D. Тогтмол цалингүй хөдөлмөр /улирлын чанартай/ E. Оюутан, сурагч F. Тэтгэвэрт G. Ажилгүй /хөдөлмөрийн чадвартай/ H. Ажилгүй /хөдөлмөрийн чадваргүй/
Хуванцар савны талаарх мэдлэгийг үнэлэх асуулт		
1	Хуванцар савны тэмдэг, тэмдэглээний талаар мэдээлэл авч байсан уу?	A. Тийм B. Үгүй C. Мэдэхгүй
2	Хуванцар савны хэдэн төрлийн тэмдэг, тэмдэглэгээ байдаг вэ?	A. 6 B. 8 C. 7 D. 5 E. 3
3	Доорх хуванцар савны тэмдэглэгээнүүдээс аль нь хүнсний зориулалтаар ашиглаж болох вэ? /Олон хариулттай/	<ul style="list-style-type: none"> ▪ 2 /HDPE/ ▪ 4 /LDPE/ ▪ 5 /PP/ ▪ 1 /PETE/ ▪ 3 /V/

4	Доорх хуванцар савны тэмдэглэгээнүүдээс аль нь хүнсний зориулалтаар хэрэглэж болохгүй вэ? /Олон хариулттай/	<ul style="list-style-type: none"> ▪ 2 /HDPE/ ▪ 4 /LDPE/ ▪ 5 /PP/ ▪ 1 /PETE/ ▪ 3 /V/ ▪ 6 /PS/ ▪ 7 /OTHER/
5	Доорх хуванцар савны тэмдэглэгээнүүдээс аль нь зөвхөн нэг удаагийн зориулалтаар ашиглах вэ? /Олон хариулттай/	<ul style="list-style-type: none"> ▪ 2 /HDPE/ ▪ 4 /LDPE/ ▪ 5 /PP/ ▪ 1 /PETE/ ▪ 3 /V/
6	Хүнсний зориулалтын бус хуванцар сав хүний эрүүл мэндэд хортой юу. Үүнийг та мэдэх үү?	<p>A. Тийм B. Үгүй C. Мэдэхгүй</p>
7	Хүнсний зориулалтын бус хуванцар сав нь хүний бие махбодид ямар сөрөг нөлөө үзүүлэх вэ? /олон хариулттай/	<ul style="list-style-type: none"> ▪ Хорт хавдар үүсгэнэ ▪ Ургийн гажиг ▪ Зүрхний судасны гажиг ▪ Сэтгэн бодох, ой тогтоолт муудах ▪ Үргүйдэл ▪ Бусад...../бичих/ ▪ Мэдэхгүй
8	Хүнсний зориулалтын бус хуванцар сав нь хүний эрүүл мэндэд хортой ямар химийн бодисыг ялгаруулдаг вэ? /олон хариулттай/	<ul style="list-style-type: none"> ▪ Хлорид ▪ Флатат ▪ ВРА-бисфенол А ▪ Хартугалга ▪ Хүнцэл ▪ Мэдэхгүй ▪ Бусад...../бичих/
Хуванцар савны талаарх дэдлэг үнэлэх асуулт		
1	Та ундны усны зориулалтаар ямар төрлийн сав хэрэглэдэг вэ?	<p>A. Хуванцар сав B. Төмөр сав C. Модон болон торхон D. Бусад..... /бичих/</p>
2	Хуванцар сав хэрэглэдэг бол ямар тэмдэглэгээтэй сав хэрэглэж байна вэ?/савны тэмдэглэгээг харах/	<p>A.2 /HDPE/ B. 4 /LDP/ C. 5 /PP/ D.1 /PETE/ E. 3 /V/ F. 6 /PS/ G. 7 /OTHER/ H.Тэмдэглэгээгүй/хөх, цагаан, шар канистер/ I. Бусад...../бичих/</p>
3	Та цагаан идээг хадгалахдаа ямар төрлийн сав хэрэглэдэг вэ?	<p>A. Хуванцар сав B. Төмөр сав C. Мод болон торхон D. Бусад...../бичих/</p>
4	Хуванцар сав хэрэглэдэг бол ямар тэмдэглэгээтэй сав хэрэглэж байна вэ? /савны тэмдэглэгээг харах/	<p>A. 2 /HDPE/ B. 4 /LDP/ C. 5 /PP/ D. 1 /PETE/ E. 3 /V/ F. 6 /PS/</p>

		G. 7 /OTHER/ H. Тэмдэглэгээгүй /хөх, цагаан, шар канистер/ I. Бусад...../бичих/
5	Та ундны ус болон цагаан идээ хадгалах савыг 7 хоногт хэдэн удаа угааж цэвэрлэдэг вэ?	A. 1-2 удаа B. 3-4 удаа C. Өдөр бүр
6	Та саваа цэвэрлэхдээ ямар төрлийн бодис ашигладаг вэ?	A. Содын уусмал B. Зориулалтын угаагч шингэн бодис C. Цэвэр усаар
7	Та ундны зориулалтаар ямар төрлийн шанага хэрэглэдэг вэ?	A. Хуванцар B. Төмөр C. Хөнгөн цагаан D. Модон E. Бусад...../бичих/
8	Та хуванцар шанага хэрэглэдэг бол тэмдэглэгээг бичнэ үү?	A. 2 /HDPE/ B. 4 /LDP/ C. 5 /PP/ D. 1 /PETE/ E. 3 /V/ F. 6 /PS/ G. 7 /OTHER/ H. Тэмдэглэгээгүй I. Бусад...../бичих/
9	Ундны усанд хэрэглэж байгаа савыг хаанаас худалдан авдаг вэ?	A. Худалдааны төв B. Зориулалтын хүнсний сав худалдан борлуулдаг компани C. Хувь хүн D. Бусад...../бичих/

Хуванцар савны талаарх хандлагыг үнэлэх асуулт

1	Хуванцар савны тэмдэг тэмдэглэгээг уншиж, таньж чаддаг уу?	A. Тийм B. Үгүй C. Мэдэхгүй
2	Ундны ус хадгалах болон зөөвөрлөх сав нь тусдаа байдаг уу?	A. Тийм B. Үгүй C. Мэдэхгүй
3	Ус хадгалах сав нь тагтай юу?	A. Тийм B. Үгүй C. Мэдэхгүй
4	Зориулалтын хуванцар сав хэрэглэхийг эрмэлздэг үү?	A. Тийм B. Үгүй C. Мэдэхгүй
5	Сүү, тараг, жүүс, ундааны сав, хоолны сав гэх мэт нэг удаагийн зориулалттай хуванцар савыг хүнсний зориулалтаар дахин хэрэглэдэг үү?	A. Тийм B. Үгүй C. Мэдэхгүй
6	Хүнсний зориулалтын усны савыг зах зээлд хямд үнээр худалдаалагдаж байвал та авч хэрэглэх үү?	A. Тийм B. Үгүй C. Мэдэхгүй
7	Хэрэв зориулалтын бус хуванцар савнаас шалтгаалан	A. Эрүүл мэндийн байгууллагад хандаж, эмчээс зөвлөгөө авна

	таны бие махбодид сөрөг нөлөө үзүүлвэл ямар арга хэмжээ авах вэ?	В. Биед илэрч байгаа шинж тэмдэг бага учраас тийм ач холбогдолтой биш С. Ямар ч арга хэмжээ авахгүй D. Мэдэхгүй
8	Хүнсний зориулалтын хуванцар сав худалдан авч хэрэглэхэд ямар бэрхшээл тулгардаг вэ?	А. Үнэ, өртөг өндөр байдаг В. Олдоц бага С. Хэрэглэж хэвшээгүй учраас худалдаж авдаггүй D. Бусад /Бичих/
9	Хуванцар савны тэмдэг, тэмдэглэгээ, хэрэглээний талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ? /олон хариулттай/	А. Телевиз В. Радио С. Цахим сүлжээ D. Эрүүл мэндийн байгууллагаас E. Сонин, сэтгүүл F. Гэр бүл, найз, нөхөд G. Хамт олон

Асуултанд цаг гарган хариулж бидний ажилд тусалсан танд баярлалаа.